



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1126

Улаанбаатар хот

Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэгийн  
эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,188,956 (таван сая нэг зуун наян найман мянга есөн зуун тавин зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэг (Ж.Одгэрэл)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 9 нэр төрлийн 2,122,276 (хоёр сая нэг зуун хорин хоёр мянга хоёр зуун далан зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 4 нэр төрлийн 3,066,680 (гурван сая жаран зургаан мянга зургаан зуун ная) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 55,000 (тавин таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 16,500 (арван зургаан мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэг (Ж.Одгэрэл)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000933



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 498/2021 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн 140 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж:													
1	Угаалгын машин	11	ш	1	216,680	216,680	216,680	-	эвдэрсэн	10,000	10,000	10,000	10,000
2	Тоос сороч	11	ш	1	210,000	210,000	210,000	-	эвдэрсэн	5,000	5,000	5,000	5,000
3	Цахилгаан дрель	11	ш	1	140,000	140,000	140,000	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
4	Люминатор	11	ш	1	110,000	110,000	110,000	-	эвдэрсэн	2,000	устгах	устгах	устгах
5	1 дүгээр хоолны тогоо	11	ш	1	2,640,000	2,640,000	2,640,000	-	эвдэрсэн	40,000	40,000	40,000	40,000
Машин, тоног төхөөрөмжийн дүн						<b>3,316,680</b>	<b>3,316,680</b>	-		<b>57,000</b>	<b>55,000</b>	<b>55,000</b>	<b>55,000</b>
Тавилга, эд хогшил													
6	Вандан сандал	11	ш	7	30,417	212,919	212,919	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
7	Сэтгүүлийн том тавиур	11	ш	3	40,000	120,000	120,000	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
8	Гацуур мод	11	ш	1	120,000	120,000	120,000	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
9	Сургалтын ширээ	11	ш	4	76,383	305,532	305,532	-	эвдэрсэн	1,000	4,000	устгах	устгах
10	Сургалтын ширээ	11	ш	8	72,000	576,000	576,000	-	эвдэрсэн	1,000	8,000	устгах	устгах
11	Сандал	11	ш	2	23,860	47,720	47,720	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
12	Багш сандал	11	ш	3	67,035	201,105	201,105	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
13	Ширээний тумбочка	11	ш	2	144,500	289,000	289,000	-	эвдэрсэн	устгах	устгах	устгах	устгах
Тавилга, эд хогшлын дүн						<b>1,872,276</b>	<b>1,872,276</b>	-			<b>12,000</b>	-	-
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн													
Үүнээс: Худалдах хөрөнгө						5,188,956	5,188,956	-					
Устгах хөрөнгө						3,066,680	4,313,144						
Худалдсанаас олох орлого						2,122,276	875,812						
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/						55,000							
						16,500							